# АЛБАН ХААГЧ, АЖИЛТНЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

1. Зорилго

Энэхүү журам нь “Радио телевизийн улсын төсөвт” ҮТҮГ- албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах үйл явцыг тодорхойлох, ил тод, шударга журмаар шалгаруулалт явуулах замаар боловсон хүчин сайжруулах, байгууллагын үйл ажиллагааг дэмжих зорилготой.

2. Хууль зүйн үндэслэл

“Радио телевизийн улсын төсөвт”ҮТҮГ-т төрийн үйлчилгээний албан тушаалд иргэнийг ажилд авахдаа Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын Дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам бусад холбогдох дүрэм, журамд нийцсэн байна..

3. Шалгаруулах шаардлагууд

- Боловсрол: Холбогдох мэргэжлээр их дээд сургуулийг төгссөн байх.
- Туршлага: Тухайн салбарт ажилласан туршлагатай байх Лавлагаа ажлын байраас хамааран тусгай шаардлага байх.
- Мэргэжлийн ур чадвар: Ажил үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар эзэмшсэн байх.

4. Сонирхож буй албан хаагчийн мэдээлэл авах

Хүний нөөцийн асуудал эрхэлсэн ажилтан ажилд орохыг хүссэн иргэдийн бүрдүүлж ирүүлсэн доорх баримт бичгийг хүлээн авч Радио телевизийн улсын төсөвт ҮТҮГ-ын захиралд танилцуулна. Үүнд:

5.3.1 Ажилд орохыг хүссэн өргөдөл
5.3.2 Төрийн албан хаагчийн анкет
5.3.3 Хувь хүний намтар 3 үеийн
5.3.4 Диплом мэргэжлийн үнэмлэхний хуулбар
5.3.5 Иргэний үнэмлэхний хуулбар /Цахим үнэмлэх/
И-Монголия
5.3.7 Шагналуудын гэрчилгээний хуулбар
5.3.8 Оршин суугаа газрын тодорхойлолт /Лавлагаа/
И-Монголия
5.3.9 Цээж зураг 3 хувь /4*6 хэмжээтэй/
5.3.10 Ял шийтгэлгүйг нотлох лавлагаа
И-Монголия
НДШ төлөлтийн лавлагаа /Бүх оноор авна/
И-Монголия
Гэрээс ажил хүргэлх маршрут

5. Радио телевизийн улсын төсөвт ҮТҮГ-т ажилд авах, ажилтан албан хаагчийг ажлаас чөлөөлөх асуудлыг тус газрын захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

6. Ажилтан, албан хаагчийн хувийн хэрэг, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэх ажлыг хүний нөөц хариуцсан ажилтан хийж гүйцэтгэнэ.